

ТЭМЦЭЭНИЙ ЗАР

„Hallo Deutschland“ – Герман хэл сурч буй оюутнуудад зориулсан тэмцээн

2026 оны сэдэв: Community in Deutschland

Герман хэл сурч буй сурагчид болон насанд хүрэгчдийн сонирхлыг герман хэл, соёлд хэрхэн хөтлөх вэ? Тодруулбал, суралцагчдыг 45 минутад өдөр тутмын амьдрал, орчин нөхцөл нь төдийлөн танил бус хэл, соёлтой хэрхэн холбож, идэвхтэй ажиллуулах вэ?

Үүнийг та бүхэн нэгж хичээлийн төлөвлөгөөгөөр харуулах учиртай!

„Hallo Deutschland 2026“ – Зүүн болон төв азийн бүсийн хэмжээнд зохион байгуулагдаж буй уг тэмцээн нь Тайвань, Монгол, Японы их, дээд сургуулиудад герман хэл сурч буй оюутнуудад зориулсан уралдаан бөгөөд багууд герман хэлний A1, A2 түвшний ахлах ангийн сурагчид эсвэл насанд хүрэгчдэд зориулсан 45 минутын нэгж хичээлийн төлөвлөгөө боловсруулж, түүний дагуу ЕБ-ын сургууль эсвэл хэлний төвд хичээл зааж өрсөлдөнө.

2026 оны сэдэв: „Community in Deutschland“

"Community" буюу хүмүүсийн нэгдэл холбоо нь Германы өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг бөгөөд

- хөршүүд,
- хороо, хороолол,
- олон нийтийн орчинд зэрэг хүмүүсийн амьдралын шууд орчинд оршиж байдаг.

Эдгээр нь зөвхөн газарзүйн хувьд биш, хүмүүс уулзалдаж, хэлээр харилцаж, хамтын амьдрал өрнөж байдаг соёлын орон зайд мөн оршдог.

Тиймээс энэхүү уралдааны зорилго нь зөвхөн Герман орон, германы хотуудыг таниулах бус, харин хэл сурах үйлийг соёлыг ойлгох үйлтэй уялдуулах явдал юм.

Төлөвлөсөн нэгж хичээл нь суралцагчдад амьдарч буй орчин болон олон нийтийн газрын өдөр тутмын тодорхой нөхцөл байдалд ашиглагдах хэлний анхан шатны хэрэглүүрүүдийг сурахын зэрэгцээ Германы хамтын амьдралын соёлын хэв маягийг танин мэдэх боломжийг олгох ёстой.

Суралцагчдыг насанд нь тохируулан хэл, соёлд хөтлөх, заах аргагүйн бүтээлч санаануудыг бид хайж байна. Хичээл төлөвлөхөд тань дараах асуултууд чиг баримжаа олгож болох юм:

- *Суралцагчид амьдаач буй хороо, хороололдоо байгаа газрууд, болж буй үйл явдал, нөхцөл байдлыг дүрслэхийн тулд ямар үг хэллэг сурах хэрэгтэй вэ?*
- *Комьюнити буюу хамтын нэгдэл нь олон нийтийн хүрээнд хэлний хувьд хэрхэн танигддаг вэ?*
- *Өдөл тутамд хамтын амьдралын болон соёлын ямар хүчин зүйлс илэрч байдаг вэ?*
- *Суралцагчид гадаад хэлээр хэрхэн идэвхтэй харилцаж, орчноо илэрхийлж чадах вэ?*

Төлөвлөж буй Хичээл тань хороо дүүрэг, хөршүүд, олон нийтийн нийтлэг газруудад чиглэх ч суралцагчдын хэл, соёл сурах үйл явцыг эн тэргүүнд чухалчлах учиртай.

Оролцогчдыг сонирхолтой шагналууд, мөн Германы Берлин хот дахь Гёте-Институтийн хоёр долоо хоногийн сургалтад хамрагдах боломж хүлээж байна. Та энэ боломжийг ашиглан, Гёте-Институтийн хэлний элч төлөөлөгч болоорой!

Шагнал

1-р байр

Берлин дэх Гёте-Институтэд хоёр долоо хоног сурах хэлний сургалтын бүрэн тэтгэлэг

Хамт суралцагчид: Япон, Тайваны оюутнууд

Хугацаа: 2026.08.17 – 2026.08.28

Явах өдөр: 2026.08.16

Буцах өдөр: 2026.08.29

Тэтгэлэгт багтсан зүйлс:

- **Онгоцны зардал**
- **Сургалтын төлбөр**
- **Байр**
- **Хоол**
- **Эрүүл мэндийн даатгал**

2 болон 3-р байр

Монгол дахь Гёте-Институтийн сургалт эсвэл шалгалтын эрх

Хүчинтэй хугацаа: 2027.06.30 хүртэл

Тавигдах шаардлага

- Хоёр хүнээс бүрдсэн баг оролцоно.
 - Багийн гишүүд:
 - Монголын их дээд сургуульд суралцдаг байх
 - Монгол хэлтэй (эх хэл)
 - Германыг гадаад хэл болгон сурч байгаа (B1 түвшинтэй байх)
 - Гадаад паспорттай байх
-

Бүрдүүлэх материал

- Герман хэл дээр бөглөсөн бүртгэлийн маягт
- Motivationsschreiben – Герман хэл дээр
- 45 минутын хичээлийн төлөвлөгөө (герман болон монгол хэлээр), 3–5 хуудас
 - мөр хоорондын зай: 1.5
 - үсгийн хэмжээ: 12 pt
- Үсгийн фонд: Times New Roman / Arial
- Оюутны үнэмлэх
- Гадаад паспортын хуулбар
- Герман хэлний түвшинг батлах нотолгоо (байгаа бол)

Бүх материалыг цахимаар дараах мэйл хаягаар илгээнэ үү: Ariuntsetseg.Ganbold@goethe.de

- Материал хүлээн авах сүүлийн хугацаа: 2026 оны 4-р сарын 10 (Баасан)

Хэрэв нэг долоо хоногийн дотор баталгаажуулалтын мэйл ирэхгүй бол дараах хаягаар холбогдоно уу: Ariuntsetseg.Ganbold@goethe.de

- Утас: 9581 2633

Шалгуур үзүүлэлт:

- Бүтээлч, өвөрмөц, шинэлэг санаанууд
 - Суралцагчдын нас, түвшинд тохирсон хичээлийн агуулга
 - Сурахуйн зорилго, зорилтууд болон цагийн төлөвлөлтийг арга зүй, дидактикийн хувьд зохистой боловсруулсан байдал
 - Суралцагчдын насанд тохирсон сургалтын материал, медиа хэрэгслийг сонгосон болон боловсруулсан байдал
 - Багийн гишүүдийн герман хэлний мэдлэгийн түвшин
-

Сонгон шалгаруулах үйл явц

1. Урьдчилсан шалгаруулалт

Ирсэн бүх материалаас 6 баг сонгож,
2026.04.17-нд Goethe-Institut Монголын вэбсайт дээр зарлана.

2. Танилцуулга хийх эцсийн шат

2026 оны 5-р сарын 9-нд Тайвань, Монгол, Япон улсуудаас шалгарсан багууд хичээлийн төлөвлөгөөгөө онлайнаар танилцуулна. Баг тус бүр хичээлийн төлөвлөгөөгөө 20 минутын хугацаанд герман хэлээр танилцуулна. Шүүгчид танилцуулгыг дээр дурдсан шалгууруудад үндэслэн, мөн оролцогчдын герман хэлний мэдлэгийн түвшинг харгалзан үнэлнэ. Улс тус бүрээс шалгарсан ялагч багуудыг тухайн өдөрт нь зарлана.

Ялагч багуудын үүрэг:

1. Гэрээ байгуулах

Гёте-Институттэй эрх, үүрэгтэй холбоотой гэрээ байгуулна.

2. Аргазүйн воркшоп

2026 оны 5-р сарын 16-нд Япон болон Тайваниас шалгарсан багуудтай хамтдаа цахим сургалтад оролцоно. Тус сургалт нь боловсруулсан хичээлийн төлөвлөгөөг аргазүйн хувьд сайжруулах, оновчтой болгох зорилготой. Сургалтыг Гёте-Институтийн багш нар удирдан, мэргэжлийн санал, зөвлөгөө өгөх болно.

3. Хичээлийг хэрэгжүүлэх

1-р байранд шалгарсан багууд:

- 2 өөр сургуульд хичээл заана.
 - 2026.05 сарын эцэс хүртэл 1 удаа
 - Германаас ирсний дараа 2026.11 сар хүртэл 1 удаа

2 ба 3-р байранд шалгарсан багууд:

- 2 өөр сургуульд нийт 2 удаа
– 2026.11 сар хүртэл

4. Олон нийттэй харилцах ажил

Ялагч багуудыг танилцуулах, мөн Гёте-Институтийн хөтөлбөрүүдийг сурталчлах зорилготой **богино хэмжээний видео ярилцлагад** оролцоно.
